



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын хүүхдийн арван дөрөвдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/199/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн
		Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	92.9	55.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,391.2	1,450.1
	Нийт хөрөнгийн дүн	1,484.1	1,505.7
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,484.1	1,505.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,484.1	1,505.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,607.8	313.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	123.7	335.8
	Үйл ажиллагааны үр дүн	1,484.1	(22.7)
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,484.1	(22.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,528.4
	Тайлант оны үр дүн	1,484.1	(22.7)
	Эцсийн үлдэгдэл	1,484.1	1,505.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	201.3	340.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	199.1	324.6
	Үйл ажиллагааны ЦМГ	2.3	16.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	175.2	312.8
	Урсгал зардал	172.7	312.8
	Хөрөнгийн зардал	2.5	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	172.7	312.8
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	165.3	312.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	7.4	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайншанд сумын хүүхдийн арван дөрөвдүгээр цэцэрлэгийн нь багш, эцэг эх, хүүхдийн гуравласан холбоог сайжруулан хүүхдийн хүсэл, сонирхолд нийцсэн хичээлийн үйл ажиллагааг зохион байгуулан хүүхэд багшийг олон талаар нь хөгжүүлэх зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2020 оны 9 дүгээр сард шинээр байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тайлант онд нягтлан бодогч солигдож гэрээт нягтлан бодогч ажиллуулж байна. Ажилчдын ажлаас гарах, ажилд орох хөдөлгөөн ихтэй. 2021 онд Ковид-19 цар тахлын улмаас 3, 9, 11, 12 саруудад үйл ажиллагаа явуулж хүүхэд хүлээж авсан ч хүүхдийн тоо мөн үеийнхээс харьцангуй бага тооны ирцтэй ажилласан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант онд тус байгууллага 110.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж баланст бүртгэснээс 38.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нь өмнөх оны авлагатай хөрөнгө, 47.3 сая төгрөг үнийн дүн бүхий газар бүртгэж авсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан араг хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 64.4 сая төгрөгийн 1 ажил, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 228.3 сая төгрөгийн 14 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 351.7 сая төгрөгийн 30 гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 35 тушаалыг тус тус бүрэн мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 87.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 65.5 сая төгрөгийн алдааг залруулж, 21.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

1. Бараа материалын зарлагын журналаас аж ахуйн материал худалдан авах зардалд тусгасан 0.4 сая цэвэрлэгээний материалын зарцуулалтын 53 гүйлгээг аж ахуйн материал худалдан авах зардалд дансанд тусгасныг аудитыг явцад бүртгэлийг залруулав.
2. Цалингийн зардлаас даатгуулагчийн төлөх НДШ-ийн 0.2 сая төгрөгийг ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын зардлаас гаргаж үр дүнгийн тайланд бодит гарсан зардлаар тусгаагүй бичилтийг аудитын явцад залруулав.
3. Барилга байгууламж, орон сууц данс элэгдлийн эхний үлэгдэл 2,3 сая төгрөг, зам гүүрний байгууламж дансны элэгдлийн эхний үлдэгдэл 0.4 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө данс 0.2 сая төгрөгөөр санхүү байдлын тайлан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналтай тус тус зөрүүг аудитын явцад залруулав.

Төлбөрийн акт

1. Тайлант онд ээлжийн амралтыг биеэр эдлэх хугацаанд цалинг ажилласнаар тооцож давхардуулан олгосон 4 албан хаагч,
2. Орон нутагт ажилласны нэмэгдэл 8%-ийг үндэслэлгүйгээр нэмж олгосон 1 албан хаагч,
3. Дотоод журамд заасан ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийн хувийг олгосон 1 албан хаагчид тус тус буцааж төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон

Албан шаардлага

1. Тайлант онд цалингийн сангаас даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 272,397 төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас бүрэг хооронд зөвшөөрөлгүйгээр зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Зөвлөмж**НББ-ийн дансны бичилттэй холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Т Албан хаагчдын бодогдсон цалин хөлсийг цалингийн өглөгийн дансанд тусгаагүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3.6 /Тайлангийн хугацаанд цалингийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ/-ийн дагуу НББ-ийн ажил гүйлгээг бүртгэж ажиллах.

Дээрх актын биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 30, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дүгээр сарын 25-ны өдрүүдийн дотор тус тус ирүүлнэ үү.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	5	4.9	3	3.7	1	1.01	1	0.2	1	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	5	4.9	3	3.7	1	1.01	3	0.2	1	0